

Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны тайлан





Хэрэглэгчийн мэдээлэл

Хэрэглэгчийн код

Нууц үг

Нууц үг солих

- Зээлийн ангилал:
1. Хэвийн – Ногоон – Сар дотроо төлбөр хийгдсэн
 2. Хугацаа хэвэрсэн – Цэнхэр – 3 сар дотроо байгаа
 3. Хэвийн бус – Шар – 6 сар дотроо байгаа
 4. Эргэлзээтэй – Хүрэн – 1 жил дотроо байгаа
 5. Мүү зээл – Улаан – 1 жилээс хэтэрсэн

2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/2191 дугаартай чиглэлийн дагуу УИХ-ын 40 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх сан хоршоо хөгжүүлэх сан болсон.

2022 оны 12 дугаар сарын 15-ны нийт 26 зээлдэгчээс Хэвийн зээлдэгч 14 , хугацаа хэтэрсэн 9, найдваргүй 3 зээлдэгчийн 11 229 144 төгрөг байна.

Хугацаа хэтэрсэн зээлдэгч нарт цаг тухайд нь мэдэгдэл хүргэж, зээлийн төлөлтийг хийлгэн ажиллалаа.

Хугацаа хэтрэлттэй 1 иргэн үндсэн зээл 2 600 000 төгрөг, зээлийн хүү 549 757 төгрөг, хугацаа хэтэрсэн алданга 547 266 төгрөг нийт 3 696 983 төгрөг шүүхэд шилжиж шүүхийн шийдвэр гарсан.

Одоогийн байдлаар байдлаар Хоршоо хөгжүүлэх сангийн нийт зээлийн үлдэгдэл **113.482.113** төгрөг байна.

2022 оны Хоршоо хөгжүүлэх сангийн тайлан



Хоршоо хөгжүүлэх санд 2022 онд орсон зээлийн хүүгийн авлага 3 486 021 төгрөг, үндсэн зээл 77 046 861,17 төгрөг нийт 80 532 883 төгрөг орсон.

2022 оны жилийн эцсийн зээлийн үлдэгдэл

Хүү: 3 864 224

Үндсэн зээл: 215 337 959.154

Нийт зээлийн үлдэгдэл: 219 202 183,154


2023 оны эхний улиралд 17 597 014 төгрөгний зээлийн эргэн төлөлт хийгдсэн.

Зээлийн хугацаа дууссан 2 иргэнийг шүүхийн эвлэрүүлэн жуучлахад шилжүүлсэн.

Хугацаа хэтэрсэн зээлдэгч нарт алданга тооцож, мэдэгдэх хуудас өгөн ажиллалаа.



Сумын иргэдийн хурлаар баталсан чиглэлийн дагуу Д.Хадхүү Дотор мах дайвар бүтээгдэхүүн боловсруулах – 60 сая төгрөг, Ц.Оргилбулаг “Өрнөх дэлгэрэх” төсөл 35 сая, М.Банзрагч, П.Зулцэцэг “Бренд гутал” төсөл 11 сая төгрөг, Д.Ичинхорлоо “Фитнесс-04” төсөл 10 сая нийт 4 төслийн 116 сая төгрөгийн санхүүжилтыг олгохоор шийдвэрлэлээ.





ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Зээл авсан иргэдийн төслийн хэрэгжилт, мөн зээлийн төлөлтөнд хугацаа хэтэрсэн шалтгаан болон цаашид анхаарах зүйлийн талаар хяналтын зөвлөл иргэдийн санал хүсэлтийг авч ажиллаж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл дарга Н.Оюунгэрэл, Б.Хишигбаяр, Б.Эрдэнэцацрал, М.Оюунчимэг, Ж.Пүрэвжав гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг төсөл хэрэгжүүлж байгаа иргэдийн үйл ажиллагаатай танилцаж, явцын хяналт хиилээ.

Г.Идэрчулуун нь 2021 онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл 10 000 000 төгрөгийн зээл авсан.

Явуулж буй үйл ажиллагаа:

- пийшин зуух
- чиргүүл пийшин
- машины өндөрлөгөө
- тэвштэй машин шаллах
- машины төмөр ARB гупер
- морины тамга
- машины ачаа
- малын угсардаг хашаа, хашааны гүйдэг хаалга



Д.Равдан 2020 онд

10 000 000 төгрөгийн зээл
авч ажлын байраа
шинэчилсэн.

Үйл ажиллагаа, тоног
төхөөрөмжийн ажиллагаа
хэвийн байна.



Д.Батчулуун нь 2014 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2021 онд Хоршоо хөгжүүлэх сангаас “Өгөөмөр засварын газрын өргөтгөл” хийх 10 000 000 төгрөгийн зээл авсан



Д.Баяраа “Малын тэжээлийн ургамал тариалах” төсөл 17 000 000 төгрөг

30 га -д тариалалт хийж, 9 тн ургац хураан авсан.



Н.Энхтөгс “Дагалдах од шинэчлэл” 20 000 000 төгрөг төслөөр эмийн сангийн байраа шинэчилсэн.



2021 онд Ч.Сүхбат “Хонины арьс боловсруулах” төсөл бичиж 20 000 000 төгрөг зээл авсан. Жилд дунджаар 1000 арьс элддэг. Түүхий эдийн олдоц элбэг бол жилийн 4 улиралд ажиллах боломжтой. Элдсэн арьсаа бүтээгдэхүүн болгох зорилготой.



Д.Зоригтбаатар “Эко тавилга үйлдвэрлэл” төсөл 10 000 000 төгрөгийн санхүүжилт авсан. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

- Бүх төрлийн модон тавилга
- Гэрийн унь, тоонь, хаалга,
- Хуучин модон авдар сэргээн засварлах үйл ажиллагаа явуулж байна.

